

ОРОН НУТГИЙН ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ ОРОЛЦОГЧ БОЛОХ НЬ

Нийгэм судлал

10-р анги

Багш Д.Уранцэцэг

III улирал.

Email: D.Urantsetseg55@yahoo.com

ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

- Орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага олон улсын харилцааны оролцогч болохыг жишээ, тохиолдол шинжилж, тайлбарлах
- Орон нутаг, байгууллагын амьдралын бодит жишээ, тохиолдлыг шинжилж, мэдээлэл цуглуулах, үнэлэх замаар орон нутгийн төрийн, төрийн бус байгууллага Олон Улсын Харилцааны улс бус оролцогч болохыг тайлбарлана



ТУЛГУУР ОЙЛГОЛТ

- Олон Улсын харилцааны үндсэн оролцогч-НҮБ-ийн гишүүн улсууд
- Олон Улсын харилцааны улс бус оролцогч –Үндэстэн дамнасан корпорациудын үйл ажиллагаа
- Олон Улсын Улаан Загалмай, Улаан Хавирган Сар Нийгэмлэг нь хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалж, хүн бүрийг хүндэтгэх, хамгаалах, зовлон шаналалыг нь хөнгөвчилж, тус дэм болох зорилттой байгуулагдсан олон улсын хүмүүнлэгийн хөдөлгөөн юм.



Орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага олон улсын харилцааны оролцогч болох нь

Монголын орон нутгийн удирдлага аймаг, сумдын Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын зүгээс хил залгаа орших ОХУ-ын Буриад, Тува, БНХАУ-ын ӨМӨЗО зэргийн хил залгаа бүс нутгийн хот, орон нутгийн байгууллагуудтай хамтран нутгаа хөгжүүлэх зорилгоор хамтын ажиллагаа, түншлэлийн гэрээ, хэлэлцээр байгуулах, төсөл хэрэгжүүлэх, худалдаа хийх, аялал жуулчлал солилцох замаар аймаг сумдын төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран ажилладаг.



ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

Төрийн бус байгууллага нь төр засгийн оролцоогүйгээр сайн дурын үндсэн дээр иргэдийн санаачилсан үйл хэрэг өргөжиж, улс, үндэстэн дамнасан төрөл бүрийн байгууллага Олон улсын байгууллага хоорондын харилцаа, хамтын ажиллагаанд тодорхой үүрэг чиглэлээр оролцож, нөлөө үзүүлдэгээрээ Олон улсын харилцааны оролцогч болдог.




ОЛОН УЛСЫН УЛААН ЗАГАЛМАЙ, УЛААН ХАВИРГАН САР НИЙГЭМЛЭГ



1919 онд байгуулагдсан. Швейцарийн, Женев хотод байрладаг. Хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалж, хүн бүрийг хүндэтгэх, хамгаалах, зовлон шаналалыг нь хөнгөвчилж, тус дэм болох зорилготой байгуулагдсан олон улсын хүмүүнлэгийн хөдөлгөөн юм. Одоогоор дэлхий даяар нийт 97 сая сайн дурын ажилтантай.



МОНГОЛЫН УЛААН ЗАГАЛМАЙ НИЙГЭМЛЭГ

- Монголын Улаан загалмай нийгэмлэг (МУЗН) 1939.04.30нд байгуулагдсан юм.
 - МУЗН Олон Улсын Улаан Загалмай, Улаан хавирган сар нийгэмлэгүүдийн Холбоонд 84 дэх гишүүнээр 1959 онд элсэв. Зудад нэрвэгдсэн 8880 өрхөд 3 тэрбум төгрөгийн тусламж үзүүллээ.
 - Хүүхэд залуучуудын хөгжлийн төвийг байгууллаа.
 - Зүүн азийн 105 улаан загалмайч хүүхдүүдийн зуслан цугларалтыг зохион байгуулав.
 - Ази номхон далайн орнуудын гамшигтай тэмцэх багийн сургалт зохион байгуулав.
 - Гамшгийн үед ажиллах 315 сайн дурын идэвхтэнг бэлтгэв.
- 

ДААЛГАВАР-1

1. Олон улсын улаан загалмай нийгэмлэг гэж ямар байгууллага вэ?
2. Монголын Улаан Загалмай Нийгэмлэг нь Олон улсын харилцааны ямар оролцогч вэ?
3. Улс бус оролцогчийн зорилго, үйл ажиллагаа үүргийг МУЗН-ийн жишээн дээр тодорхойлж бичээрэй

Олон Улсын Улаан Загалмайн Хорооны ажлын хэсгийн дүгнэлт, төрийн ба холбогдох агентлагуудтай зөвшилцсөний дүнд Олон Улсын Улаан Загалмай, Улаан Хавирган Сар Нийгэмлэгүүдийн Холбооноос зудын гамшигт нэрвэгдсэн 17 аймгийн 115000 малчдыг гурил, хүүхдийн дулаан хувцас, том хүний гутлаар хангах зорилготой яаралтай тусламжийн уриалгыг олон улсад хандан гаргажээ. Монголын Улаан Загалмайн Нийгэмлэг нь (МУЗН) Улсын байнгын Онцгой Комиссын (УБОК) мэдээллээс үзэхэд 133000 өрхийн 665000 малчин 2009 оны ган зудын гамшигт нэрвэгджээ. 2002 оны 11 сард Олон Улсын Улаан Загалмай, Улаан Хавирган Сар Нийгэмлэгийн Холбооноос нөхцөл байдлыг газар дээр нь үнэлэх ажлыг зохион байгуулж Монгол улсад эмзэг байдлыг үүсгэж байгаа дараах гурван хүчин зүйлс байгааг тогтоожээ. Үүнд: нэгдүгээрт, байгаль, цаг агаараас хамааралтай бэлчээрийн мал аж ахуй, түүнээс хэт хараат улс орны эдийн засгийн байдал; хоёрдугаарт, 1999-2000 онд тохиолдсон цаг агаарын онцгой хүнд байдал (гал түймэр, зудын гамшиг); гуравдугаарт, нийгмийн социалист тогтолцооноос ардчилсан нийгэмд шилжих үйл явцын бэрхшээл гэж үзжээ.

Эх сурвалж: Р.Самдандовж, Улаан Загалмайн нэр томъёоны тайлбар толь бичиг УБ., 2010, 43-44 дэх тал



ДААЛГАВАР-2

1. Гаалийн байгууллагын үйл ажиллагаа олон улсын харилцаатай хэрхэн холбогдох вэ?
2. Гаалийн байгууллагыг нэгтгэсэн олон улсын ямар байгууллага байдаг вэ?
3. Монгол улсын гадаад бодлогыг хэрэгжүүлэхэд гаалийн байгууллага ямар чиг үүрэг оролцоотой байна вэ?

Гаалийн үйл ажиллагааны зорилго нь эдийн засгийн, зохицуулалтын болон эрх зүйн хамгаалалтын гэсэн 3 төрөл байна. Эдийн засгийн зорилго нь гаалийн татвар, хураамжийг авч төрийн төсвийн орлогыг бүрдүүлэх явдал юм. Хилээр бараа, гаалийн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэхэд татвар тогтоох, оруулах, гаргах харилцааг гаалийн үйл ажиллагааны зохицуулалтын зорилгоор хэрэгжүүлдэг. Эрх зүйн хамгаалалтын зорилго нь Монгол улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл орчин, хүнсний аюулгүй байдлыг хангах, нийгэм, соёлын үнэт зүйлийг хамгаалах, хар тамхи, мансууруулах бодисыг хилээр нэвтрүүлэхгүй байх эрх зүйн орчин бүрдүүлэхэд оршино.


Эх сурвалж: Ж.Жавзандулам, Ж.Батсуурь. Гаалийн эрх зүй УБ, 2005, 2 дахь тал



ДААЛГАВАР-3

1. Энэхүү нэгдмэл загвар бүдүүвчийг жишээгээр тайлбарлан бичээрэй

2. Та нарын амьдардаг орон нутагт Олон улсын харилцаанд идэвхтэй оролцдог ямар байгууллагууд байгааг сурвалжлан мэдээлэл бэлтгэх



Гэрийн даалгавар

1. ДААЛГАВАР 1,2,3-Г ДЭВТЭРТЭЭ ХИЙГЭЭРЭЙ.
2. СУРАХ БИЧГИЙН 124-126 ХУУДСЫГ САЙН УНШИЖ СУДЛААРАЙ.

